

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН БОЛОН САНХҮҮ, АЖ АХУЙН
АЛБАНЫ 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТААР ӨГӨГДСӨН
ЗӨВЛӨМЖ, ТӨЛБӨРИЙН АКТ, АЛБАН ШААРДЛАГЫН БИЕЛЭЛТ**

17.06.25

№	Санхүүгийн аудит хийлгэсэн байгууллагын нэр	Зөрчлийн ангилал	Аудитын дүгнэлтээр өгсөн				Биелэлт
			Асуудал	Хэрэгжилтийн биелэлт тайлагнах хугацаа	Хэрэгжилтийн биелэлт тайлагнасан байдал	Зөвлөмж	Хувиар
A	1	2	3	4	5	6	7
	Цагдаагийн ерөнхий газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан	Зөвлөмж	Цагдаагийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөд ашиглалтын хугацаа дуусч элэгдлээрээ анхны өртөгөө бүрэн нөхсөн 654.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 162.9 сая төгрөгийн бараа материал бүртгэлтэй байна. Дээрх үндсэн хөрөнгө, бараа материалын талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах	2017.10.05	Санхүүгийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хүрээнд хийх ажлын төлөвлөгөө гарган Санхүү, аж ахуйн албаны даргаар батлуулан биелэлтийг эхний хагас жилийн байдлаар тооцон ажиллав. Цагдаагийн ерөнхий газрын өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2017 оны 01 дүгээр хуралдаанаар уг зөвлөмжөөр өгөгдсөн асуудлыг хэлэлцээд, дотоодын цэрэг байгуулагдахад нөхөн хангалт хийх боломжгүй тул 280,3 сая төгрөгийн барилга байгууламж, авто тээврийн хэрэгсэл, 0,2 мянган төгрөгийн хийн бууг үлдээж, 374,1 сая төгрөгийн дансны үнэтэй үндсэн хөрөнгө, 160,4 сая төгрөгийн дансны үнэтэй бараа материалыг актлаж, устган данс бүртгэлээс хасах саналыг дээд шатны байгууллагуудад хүргүүлсэн. Нийт 14 байгууллагын 4 дансны 374,1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг актлаж, устгах зөвшөөрлийг Хууль зүй, дотоод хэргийн ямаар дамжуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэн, тус газрын 2017 оны 263 дугаар тогтоол, А-58/1236 тоот албан бичгээр ирүүлсэн зөвшөөрлийн дагуу уг үндсэн хөрөнгийг ЦЕГ-ын даргын 2017 оны А/118 тоот тушаалаар, 160,4 сая төгрөгийн дансны үнэ бүхий бараа материалыг Санхүү, аж ахуйн албаны даргын 2017 оны 122 дугаар тушаалаар актлаж, устган данс бүртгэлээс хасч, холбогдох арга хэмжээг авч ажиллаа.	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-т "Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно", мөн хуулийн 31.2-т Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан эд хөрөнгийг худалдах, шилжүүлэхэд энэ хуулийн 29.30 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллагын зөвшөөрөл авна.	100

Цагдаагийн ерөнхий газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан	Зөвлөмж	<p>Тус байгууллагын малын данс бүртгэлд нийт 489.3 сая төгрөгийн мал бүртгэлтэй байгаа ба нэг төрлийн малын дансны үнэ өөр өөр байна. Энэ нь ЦЕГ-ын Санхүү, ар талын газрын даргын 2010 оны 131 дугаар тушаалын 2-т заасантай нийцэхгүй байна.</p>	2017.10.05	<p>Төв, орон нутгийн 31 цагдаагийн байгууллагын малын дансанд бүртгэлтэй байгаа нийт 489.3 сая төгрөгийн малын үнийг Санхүү, аж ахуйн албаны даргын 2017 оны 121 дүгээр тушаалаар шинэчлэн тогтоож, нягтлан бодох бүртгэлийн залруулга хийж санхүүгийн тайланд тусган бүртгэлийг хөтлөв.</p>	<p>Малын анхны өртгийг бодитоор тооцож, зах зээлийн ханш болон үнийн өөрчлөлтэй холбогдуулан данс бүртгэлд тусгаж байх. ЦЕГ-ын Санхүү, ар талын газрын даргын 2010 оны 131 дугаар тушаалын 2-т "Зах зээлийн ханш, үнийн өөрчлөлттэй холбогдуулан жил бүр малын үнийг тогтоож батлуулах" гэж заасныг мөрдөж ажиллах</p>	100
		<p>Цагдаагийн ерөнхий газрын 2016 оны үндсэн үйл ажиллагааны орлогыг 9.851.90 сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 8.759.0 сая төгрөг буюу 1.092.9 сая төгрөгөөр дутуу биелүүлжээ. Нэр бүхий 25 байгууллага 1.233.5 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөөг тасалдуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.</p>	2017.10.05	<p>Цагдаагийн ерөнхий газрын төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2017 оны өөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлд сар бүр дүн шинжилгээ хийж ажилласнаар 2017 оны 05 дугаар сарын байдлаар үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 3,733,986,5 мянган төгрөг оруулахаас 3,901,359,9 мянган төгрөгийн орлого оруулж төлөвлөгөөг 4 хувиар буюу 167,373,4 мянган төгрөгөөр давуулан биелүүлэв.</p>	<p>Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх, орлогыг үндэслэлтэй үнэн зөв төлөвлөж төлөвлөгөөг бүрэн биелүүлэх</p>	100
		<p>Төсвийн шууд захирагчдын аудитаар 36 асуудлаар 2197.4 сая төгрөгийн залруулга, 58 асуудлаар 508.5 сая төгрөгийн зөвлөмж, 39 асуудлаар 423.4 сая төгрөгийн албан шаардлага, 10 асуудлаар 7.6 сая төгрөгийн төлбөрийн акт тус тус тогтоосон байна.</p>	2017.10.05	<p>Санхүүгийн аудитын шалгалтын дүн болон Цагдаагийн ерөнхий газрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Санхүү, аж ахуйн албаны даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж төсөв захирагч, нягтлан бодогч нарын ажлыг дүгнэж, зөвлөмжийн мөрөөр хийх ажлын төлөвлөгөөг гарган, хэрэгжилтийг хангуулах талаар тодорхой ажлуудыг зохион байгуулж, биелэлтийг тооцож ажилласнаар зөвлөмж 92,5 %, төлбөрийн акт 100 %, албан шаардлага 91,7 %-ийн биелэлттэй байна.</p>	<p>Үндэсний аудитын газар болон аймаг, нийслэлийн аудитын газраас хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлсэн алдаа зөрчлийг арилгаж, дахин давтан гаргахгүй байх, төлбөрийн актыг барагдуулах талаар анхаарч ажиллах</p>	90

Цагдаагийн ерөнхий газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан	Зөвлөмж	<p>ЦЕГ-ын 2016 оны Санхүүгийн нэгтгэсэн тайланд "Монгол тамга" ТӨҮГ, "Цагаан шонхор" ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланг нэгтгэсэн байна. Гэтэл дээрх 2 байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих удирдлагыг томилох эрх нь төрийн өмчийн хороонд байгаа бөгөөд ЦЕГ-ын хамааралгүйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.Тухайлбал эдгээр 2 ААН-ийн удирдлагыг Төрийн өмчийн хорооноос томилсон бөгөөд үйл ажиллагааны чиг үүрэг Цагдаагийн албаны тухай хууль болон Хууль зүйн сайдын 2014 оны А/167 дугаар тушаалаар батлагдсан Цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын бүтэц, ЦЕГ-ын чиг үүрэгт байхгүй байна. Иймд дээрх 2 ААН-ийн чиг үүрэг, удирдлага, хяналтын үйл ажиллагааг ЦЕГ-т хамаарах эсэхийг эцэслэн шийдвэрлэж, Төсвийн төвлөрүүлэн захирагч, түүнд харьяалагдах төсвийн шууд захирагчийг Засгийн газар тогтооно" гэсэн заалтыг үндэслэн өөрийн эрхлэх асуудлын хүрээнд харьяалах байгууллага, нэгжийн жагсаалт гаргаж баталгаажуулах асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх нь зүйтэй байна.</p>	2017.10.05	<p>Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 126 дугаар тушалаар байгуулагдсан "Төрийн өмчийг 2017-2020 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай" болон "Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай" тогтоолын төслийг боловсруулах ажлын хэсэгт "Цагаан шонхор" ТӨААТҮГ-ыг цагдаагийн байгууллагын харьяалалд шилжүүлж өөрчлөн байгуулах, "Монгол тамга" ТӨҮГ-ыг хувьчлах асуудлыг шийдвэрлүүлэх талаар Цагдаагийн ерөнхий газрын 2017 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 01/394 тоот албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогтод хүргүүлсэн ба шийдвэр гараагүй байна.</p>	<p>Төсвийн тухай хуулийн 15 дүгээр зүйлийн 15.3-т Төсвийн төвлөрүүлэн захирагч, түүнд харьяаглагдах төсвийн шууд захирагчийг Засгийн газар тогтооно гэнэс заалтыг үндэслэн өөрийн эрхлэх асуудлын хүрээнд харьяаглагдах байгууллага, нэгжийн жагсаалт гаргаж баталгаажуулах асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.</p>	50
---	---------	---	------------	--	--	----

Санхүү, аж ахуйн алба	Зөвлөмж	ЦЕГ-ын харьяа бусад газруудтай холбоотой 2300.0 мян төгрөгийн зардлыг баталсан төсвөөс санхүүжүүлсэн, томилолтын батлагдсан зардлын төсөв зөрүүтэй хийж зарцуулах шатахууныг зөрүүтэй тооцоолсон, 8800.0 мян төгрөгийг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй	2017.08.05	2017 оны эхний хагас жилд Санхүү, аж ахуйн албаны батлагдсан төсвөөс харьяа байгууллагуудын зардлыг санхүүжүүлээгүй ба төсөв хэмнэлттэй буюу дутаж байгаа төсвийн асуудлыг Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын дагуу төсөвт зохицуулалт хийх журмыг мөрдөн, төсөвт зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулж гүйцэтгэлд хяналт тавьж ажиллав.	Зөвлөмж 1. Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалын 2-р хавсралтад заасан зардлын эдийн засгийн ангиллыг дагаж мөрдөх	100
		Тус байгууллагын үндсэн хөрөнгөд ашиглалтын хугацаа дуусч элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, ашиглах боломжгүй 15600.0 мян төгрөгийн үндсэн хөрөнгө, 2700.0 мян төгрөгийн бараа материал бүртгэлтэй байна. Өмч хамгаалах байнгын зөвлөлөөр оруулж холбогдох арга хэмжээ авч ажиллав		Цагдаагийн ерөнхий газрын өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2017 оны 01 дүгээр хуралдаанаар уг зөвлөмжөөр өгөгдсөн асуудлыг хэлэлцээд Санхүү, аж ахуйн албаны дансанд бүртгэлтэй байгаа 15600.0 мянган төгрөгийн үнэтэй үндсэн хөрөнгө, 2700.0 мянган төгрөгийн үнэтэй бараа материалыг актлаж, устган данс бүртгэлээс хасах саналыг дээд шатны байгууллагуудад хүргүүлсэн. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 263 дугаар тогтоол, А-58/1236 тоот албан бичгээр ирүүлсэн зөвшөөрлийн дагуу уг 15600.0 мянган төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгийг ЦЕГ-ын даргын 2017 оны А/118 тоот тушаалаар, 2700.0 мянган төгрөгийн дансны үнэ бүхий бараа материалыг Санхүү, аж ахуйн албаны даргын 2017 оны 122 дугаар тушаалаар актлаж, устган данс бүртгэлээс хасч, холбогдох арга хэмжээг авч ажиллаа.	Зөвлөмж 2. Ашиглалтын хугацаа дуусч элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, ашиглах боломжгүй үндсэн хөрөнгө, бараа материалыг өмч хамгаалах байнгын зөвлөлөөр оруулж холбогдох арга хэмжээ авах, Төрийн болон орон нуугийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т Төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургууль дэргэдээ бие даасан гарааны компани байгуулахаас бусад тохиолдолд үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх, устгах саналаа санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах	100
		Тус байгууллагын бүртгэлд нийт 20300.0 мянган төгрөгийн дансны үнэ бүхий 692 толгой мал бүртгэгдэж, малын тооллого, нас дэвшилтийг зохих журмын дагуу хийгдэж байгаа ба зарим нэр төрлийн малын анхны өртөг өөр өөр байна.		Тус байгууллагын нийт 20300.0 мянган төгрөгийн дансны үнэ бүхий 692 толгой малын үнийг Санхүү, аж ахуйн албаны даргын 2017 оны 121 дүгээр тушаалаар шинэчлэн тогтоож, нягтлан бодох бүртгэлийн залруулга хийж санхүүгийн тайланд тусган бүртгэлийг хөтлөв.	Зөвлөмж 3. Малын анхны өртгийг бодитоор үнэлэх, ЦЕГ-ын Санхүү, ар талын газрын даргын 2010 оны 131 дугаар тушаалын 2-т "Зах зээлийн ханш, үнийн өөрчлөлттэй холбогдуулан жил бүр малын үнийг тогтоож батлуулах" гэж заасныг мөрдөж ажиллах Бараа материал байхгүй мөртлөө байгаагаар тайлагнаж бүртгэлийн болон Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар батлагдсан журмыг зөрчсөнд дүгнэлт хийж засаж залруулж, дахин давтан гаргахгүй байх	100

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН САНХҮҮ, АЖ АХУЙН АЛБА.

